



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ “АМГАЛАН ДУЛААНЫ
СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



**“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ “ АМГАЛАН
ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ
ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

РЕГИСТРИЙН ДУГААР: 6021646

УЛААНБААТАР
2024 ОН



ГАРЧИГ

ГАРЧИГ	2
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
1. ОРШИЛ.....	4
2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	5
2.1 ТӨСЛИЙН НЭР, ДУГААР.....	5
2.2 ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА.....	5
2.3 ТӨСЛИЙН ЗОРИЛГО.....	5
2.4 ТӨСЛИЙН БАЙРШИЛ.....	5
3. НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ	7
3.1. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ЭРЧИМ	7
3.2. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ	9
3.3. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ	9
3.4. ХӨРСӨН БҮРХЭВЧИД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ.....	9
3.5. УРГАМЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ	10
3.6. ТӨСЛӨӨС АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ.....	10
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	11
4.1. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
4.2. НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	14
4.3. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
4.4. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	14
4.5. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
4.6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	16
4.7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	18
4.8. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	22
ДҮГНЭЛТ	25



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АХБ	Азийн Хөгжлийн Банк
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
ОХШХ	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
БОУАӨЯ	Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
УБХЗ	Улаанбаатар хотын захиргаа
ХБ	Хамгааллын бодлого
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
НӨХГ	Нийслэлийн Өмчийн Харилцааны Газар



1. ОРШИЛ

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ийн Амгалан дулааны станц төсөл нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжиж байна.

Улаанбаатар хотын Амгалан дулааны станцын одоогийн 3х116 МВт суурилагдсан хүчин чадлыг 1х116 МВт -аар дулаан үйлдвэрлэх нэг блокоор өргөтгөнө.

Тус дулааны станц нь Багануур, Шивээ-Овоо, Алаг толгойн нүүрсээр дулааны эрчим хүч үйлдвэрлэх зориулалт бүхий дулаан эрчим хүчний үйлдвэр бөгөөд цахилгаан эрчим хүчний хэрэглээгээ “Амгалан” 110/10 кВ-ийн дэд станцаас 110 кВ-ын агаарын шугам дамжуулан “Дулаан” дэд станцын 110/10 кВ-ын 2х20 МВт-ын хүчин чадал бүхий трансформатортай 10 кВ хүртэл бууруулан дотоод хэрэгцээндээ ашиглаж байна.

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний “Экологийн бүтээмж” ХХК боловсруулсан ба тус тайланг Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”, Монгол Улсын Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан гүйцэтгэсэн юм.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын үр дүн, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө (5 жил)-нд үндэслэн, бид бүхэн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулаад байна.



2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2.1 ТӨСЛИЙН НЭР, ДУГААР

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ийн Амгалан дулааны станц төсөл

2.2 ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА

Аж ахуй нэгжийн нэр: “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ийн

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15 1-1 тоот, өөрийн байр

Утас: 7711-1252

Аж ахуй нэгжийн Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011573097

Регистрийн дугаар: 6021646

2.3 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төсөл хэрэгжүүлэгчийн үндсэн зорилго нь “Орчин үеийн дэвшилтэт технологиор эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангах”-д орших бөгөөд цаашид Амгалангийн дулааны станцын техник-эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өөрийн өргийг хямдруулах, жилийн 4 улирал тасралтгүй ажиллуулах, дулаан цахилгаан хослон үйлдвэрлэх, Улаанбаатар хотын хэрэглэгчдийг тасралтгүй найдвартай эрчим хүчээр хангах, Улаанбаатар хотын зүүн хэсгийн дулааны өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хаах зорилтуудыг тавин төслийг хэрэгжүүлж байна.

2.4 ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Амгалан дулааны станц нь Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, “Амгалан дулааны станц” ХХК-ийн өөрийн байранд байрладаг байна.


Хүснэгт 1 Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбицол

№	X	Y	Цэг	Урт	№	X	Y	Цэг	Урт
1	5310815.96	650098.89	1-2	2.18	19	5311101.03	649694.30	19-20	5.04
2	5310813.79	650099.12	2-3	146.43	20	5311105.96	649693.24	20-21	30.98
3	5310808.48	649952.79	3-4	183.63	21	5311136.25	649686.76	21-22	0.52
4	5310807.31	649769.16	4-5	3.11	22	5311136.48	649687.23	22-23	38.88
5	5310810.41	649768.93	5-6	116.03	23	5311146.06	649724.91	23-24	18.23
6	5310926.43	649770.01	6-7	23.74	24	5311151.27	649742.38	24-25	170.33
7	5310950.17	649770.38	7-8	23.92	25	5311199.19	649905.83	25-26	92.76
8	5310974.09	649770.71	8-9	33.66	26	5311192.45	649998.34	26-27	59.57
9	5311007.75	649770.39	9-10	19.03	27	5311132.92	650000.56	27-28	8.15
10	5311019.43	649755.36	10-11	3.33	28	5311134.12	650008.62	28-29	47.02
11	5311022.76	649755.41	11-12	13.10	29	5311087.48	650014.6	29-30	176.44
12	5311023.35	649742.32	12-13	9.25	30	5310912.47	650037.04	30-31	11.54
13	5311023.28	649733.07	13-14	24.66	31	5310903.07	650043.74	31-32	26.71
14	5311047.91	649731.95	14-15	25.01	32	5310882.39	650060.64	32-33	18.83
15	5311072.89	649730.72	15-16	0.04	33	5310866.34	650070.48	33-34	9.94
16	5311072.93	649730.72	16-17	30.90	34	5310857.51	650075.04	34-35	34.93
17	5311071.59	649699.85	17-18	23.39	35	5310827.34	650092.64	35-36	12.98



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТЭХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 8-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫН БАЙРШЛЫН ТОЙМ ЗУРАГ



Таних тэмдэг

- Дулааны станцын байршил
- Дулааны станцын талбай
- Дүүргийн хил

Зургийн эхийг бэлтгэсэн: "ЭКОЛОГИЙН БҮТЭЭМЖ" ХХК-ийн Байгаль орчныг зайнаас тандан судлалын мэргэжилтэн Ц.Нурбахыт Улаанбаатар хот 2019.05.15

Зураг 1. Төслийн байршлын схем зураг



3. НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ЭРЧИМ

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Амгалан дулааны станцыг 1х116МВт хүчин чадал бүхий зуухаар өргөтгөх төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг “Магадлан жагсаах” арга болон Матрицын аргаар тодорхойлов. Үүнд:

Байгаль орчны суурь үнэлгээ болон Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийн шаардлага болон манай орны нөхцөлд станцын үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийг ашиглахад гарч байсан урьд өмнөх ажлын туршлага, үйл ажиллагаа болон үйлдвэрлэлийн явцад гарч болох сөрөг нөлөөлөл, Дэлхийн банкнаас байгаль орчны үнэлгээний талаар 1991 онд гаргасан лавламж, НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос гаргасан гарын авлага зэргийг ашигласан болно.

Магадлан жагсаах арга нь нөлөөлөх зүйл байгаа-байхгүй гэсэн зарчим дээр үндэслэдэг бөгөөд сөрөг нөлөөлөл байвал “х”-ээр, эерэг нөлөөг “+”-ээр тэмдэглэдэг. Нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг илрүүлэхэд зориулагдсан бөгөөд нөлөөлөл нь шууд, шууд бус, буцах ба буцалтгүй, давхардах эсэхийг тодруулах, хугацааны хувьд урт, богино, эрчмийн хувьд ямар байхыг үзүүлдэг байна. Нөгөө нь төслийн байршил, технологийн шийдэлтэй холбоогүй төсөл хэрэгжих үеийн болзошгүй нөлөөлөл юм.

Хүснэгт 2. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах байдал

№	Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Сулавтар нөлөөлөх	Дунд зэрэг нөлөөлөх	Хүчтэй нөлөөлөх
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1. Байгалийн төрөл зүйн өөрчлөлт											
1	Газрын доорх урсцын өөрчлөлт	-				-	-	-		-	
2	Газрын доорх усны чанарын өөрчлөлт		-	-			-		-		
3	Газрын доорх усны нөөц	-				-	-	-			-
3	Ургамлын бүтцийн өөрчлөлт		-	-		-	-		-		
4	Хөрсний элэгдэл, эвдрэл		-	-			-		-		
5	Геологийн тогтцын өөрчлөлт										
6	Зэрлэг, ан амьтдын орон зайн өөрчлөлт										
7	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		-	-		-	-	-	-		
2. Байгалийн нөөцийн ашиглалт											
8	Газрын гадаргын нөөц баялаг										
9	Бэлчээр, тэжээлийн байдал										
10	Эрдэс түүхий эд, нөөц		-			-	-			-	
11	Эрчим хүчний нөөц	+				+		+			+
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
12	Ундны усны чанар өөрчлөгдөх		-		-		-		-		
13	Ундны усны нөөц хомсдох	-				-		-		-	
14	Агаарын бохирдол	-				-	-				-
15	Хөрсний бохирдол		-			-	-		-		
16	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл		-		-		-		-		
17	Дуу, чимээ шуугианы нөлөөлөл	-		-			-		-		
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор											
18	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх										
19	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх		-			-	-		-		



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

20	Тусгай хамгаалалттай газар, нутагт нөлөөлөх												
21	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх												
22	Археологи, палентологийн олдворт нөлөөлөх												
5. Нийгэмд үзүүлэх нөлөөлөл													
23	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+		+			+		
24	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх	+				+					+		
25	Хүн амын орлого нэмэгдэж өөрчлөгдөх	+				+		+		+			
26	Хүн амын тоо өөрчлөгдөх			+		+				+			
6. Эдийн засаг, байгаль орчин													
27	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх												
28	Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+		+			+		
29	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+				+		+		+			
30	Ажлын байр нэмэгдэх	+				+		+		+			
31	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+				+				
32	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх			+		+		+		+			
7. Бусад нөлөөлөл													
33	Шороон зам харилцаа, станцын машин механизмын хөдөлгөөн шилжилтээс үүдэх хөрсний эвдрэл	-				-		-	-				
34	Ахуйн бохир ус, нефьтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс ба грунтын усыг бохирдуулах.			-		-				-			
35	Ахуйн хог, хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих	-				-		-		-			
36	Хүчтэй салхи, тоосжилт	-				-							
Нөлөөллийн тоо ширхэг			Сөрөг	8	10	5	5	10	10	6	11	4	2
			Эерэг	8	2	0	1	8	0	7	2	4	4

Тайлбар: /+/- Эерэг нөлөөлөл
/-/- Сөрөг нөлөөлөл

Байгалийн экосистемийн өөрчлөлт: Станцын ашиглах тоног төхөөрөмжийн хүчин чадал их байх ба тухайн орон нутгийн байгаль-экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болон агаар орчин, усны нөөцөд шууд нөлөөлж, эдгээр нь урт хугацааны турш хүчтэй нөлөөлөлд хамрагдаж, ихэнхдээ буцалтгүй шинжтэй байна. Цахилгаан дулаан үйлдвэрлэх үйл ажиллагааны улмаас агаар орчныг бохирдуулагч хорт хий, тоос тоосонцор, дуу чимээ, усны уур үүсэх, үндсэн эх үүсвэр болох ус, нүүрсний нөөцөд үзүүлэх нөлөөлөл, улмаар хөрс ургамал, хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг энд дурдаж болох юм.

Байгаль орчны чанарын өөрчлөлт: “Амгалан дулааны станц” ХХК-ний Амгалан дулааны станц төслийн үйл ажиллагаа нь агаар, хөрсөн бүрхэвчийн чанарт ихээр нөлөөлөх бөгөөд нөлөөллийн цар хүрээ дунд зэрэг, эрчим ихтэй, удаан хугацааны нөлөөлөл юм. Нөлөөллийн эх үүсвэр нь утааны яндан, бэлтгэл ус үйлдвэрлэх үеийн хаягдал ус зэрэг байна. Гэхдээ станцын нэвтрүүлж буй технологи, тоног төхөөрөмж нь байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бага байх боломжийг бүрдүүлж байна.

Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор: Станцын өргөтгөлийн үйл ажиллагаа нь одоогийн үйл ажиллагаа явуулж буй эзэмшлийн талбайд явагдах бөгөөд байгалийн өнгө төрхөд нэмж өөрчлөлт үзүүлэх, археологи, палентлогийн олдворт нөлөөлөх нөлөөлөл бага юм.

Эдийн засаг нийгмийн асуудал: Амгалан дулааны станц төслийн үйл ажиллагаа нь улс, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулах бөгөөд ажлын байр бий болж, иргэдийн амьжиргаанд тус нэмэр болох, дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх, тэдгээрийг даган бий болох эерэг нөлөөлөл ихтэй юм. Эдгээр нь шууд бөгөөд урт хугацааны эерэг нөлөөлөлд



хамаарна.

3.2. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Төслийн үйл ажиллагааны явцад дараах болзошгүй сөрөг нөлөөллүүд агаар орчинд үүсэх боломжтой байна. Үүнд:

- ✓ Төслийн үйл ажиллагаанаас агаар бохирдуулагч бодис ялгарч төслийн талбай орчмын агаарыг бохирдуулах
- ✓ Үйлдвэрийн дотоод орчинд их хэмжээгээр тоос тоосонцор ялгарах
- ✓ Төслийн тээвэрлэлтийн явцад хучлагагүй нүүрснээс тоос тоосонцор босох
- ✓ Төсөлд ашиглах тээврийн хэрэгслүүдээс стандарт хэмжээ давсан бохирдуулагч бодис ялгарах
- ✓ Ажлын байрны дотоод орчин дахь тоосны өндөр агууламж, нүүрсний тортог зэрэг нь ажиллагсдын эрүүл мэндэд богино хугацаанд сөргөөр нөлөөлөх, урт хугацаад эрүүл мэндийн ноцтой асуудал үүсгэж болзошгүй
- ✓ Нүүрсний хадгалалт, буулгалт, ашиглалттай холбоотойгоор салхиар нүүрсний жижиг хэсгүүд зөөгдөн орчныг бохирдуулах
- ✓ Шатсан нүүрсний үлдэгдэл, ахуйн болон үйлдвэрлэлийн хаягдал, үнсний хаягдлыг гар аргаар зөөж, ил задгай ачиж тээвэрлэснээр хүний эрүүл, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх
- ✓ Үйлдвэрийн тоног төхөөрөмж, машин техникээс дуу шуугиан гарч ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх

3.3. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Амгалан дулааны станц нь ахуйн хэрэглээний усыг төвлөрсөн шугамаас харин технологийн хэрэгцээний усаа гүний худаг болон шаардлагатай тохиолдолд төвлөрсөн шугамаас нэмэлтээр авч хангана. Газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл:

- ✓ Гадаргын болон газрын доорх усны нөөц, чанарын өөрчлөлтөд нөлөөлөх
- ✓ Хөргөлтөд ашигласан усыг гадаргын усанд нийлүүлснээс дулааны бохирдол үүсэж, усны амьтан, бичил биетэд нөлөөлөх нөлөөлөл
- ✓ Хөргөх цамхаг болон үнсэн сангаас алдагдах усны уур агаар мандал дахь хатуу хольцыг (утаа, тоос тортог, хорт бодисууд) шингээснээр газрын гадаргад унаж хөрс, ургамал, усны чанарт сөргөөр нөлөөлөх
- ✓ Усны ирээдүйн болон өв залгамжлалын үнэ цэнэ алдагдах, усны нөөцийг хомсдуулах хүчин зүйл болох

3.4. ХӨРСӨН БҮРХЭВЧИД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн талбай нь Туул голын нам дэнжийн системд хамаарах бөгөөд төслийн талбайд үлдмэл нугархаг болон хээржүү хэв шинжийн цайвар хүрэн хөрс тархсан байна. Хэмжилт, судалгааны ажлын явцад хөрсөн бүрхэвчид дараах нөлөөллийн хэлбэр ажиглагдлаа.

- ✓ Станцын хашаан дотор хөрсний доройтол элэгдэл хүчтэй явагдаж, хөрс үүсгэгч эх чулуулаг ил гарсан байна. Станцын тодорхой үүрэг бүхий инженерийн байгууламжуудын хоорондох тээвэрлэлт болон тухайн байгууламжуудын үйл ажиллагааны онцлогтой уялдан хөрсний эвдрэл, бохирдол илэрсэн байна. Байгалийн үндсэн хөрсний шинж чанар өөрчлөгдсөнөөр тоосжилт дэгдэх, хүнд элементийн болон биологийн бохирдол тунаж хуримтлагдалгүй гүний усанд нэвчих,



өнгөн хөрсний элэгдэл эвдрэл эрчимжих зэрэг эрсдэл үүснэ. Ялангуяа станцын ойр орчимд нүүрсний жижиг хэсгүүд тархсанаар хүнд элементийн бохирдол үүсгэх боломжтой бол антропоген нөлөөллийн улмаас өнгөн хөрсний эвдрэл эрчимтэй явагдаж байна. LADA-Pedestal аргазүй ашиглан тооцож үзэхэд станцын талбайд хөрсний эвдрэлийн эрчим нөлөөлөл багатай талбайд 20тн/га орчим байгаа бол хөдөлгөөн эрчимтэй хэсгүүдэд 80-100тн/га орчим хүрэн хэлбэлзэж байна. энэ аргазүйгээр тооцсон хөрсний эвдрэл Хустайн нуруунд байгалийн гаралтай хөрсний эвдрэл 3-4тн/га орчим байдаг учир өндөр эрсдэлтэй бүсэд багтана.

- ✓ Станцын талбайн хөрсөн бүрхэвч хүнд элемент болон цацраг идэвхт изотопын хуримтлал үүсэх, цаашид бохирдол үүсэн агаар болон гүний усанд нэвчих эрсдэл үүснэ. Нүүрс ачиж буулгах үйл явц болон станцаас гарч буй үнсэнд агуулагдаж буй Pb, Zn, U, Th, Cd зэрэг элементүүд салхиар дамжин тодорхой цэгүүдэд хуримтлагдаж байгаа тул геохимийн гажиг үүсгэн, бохирдол бүхий бүсийг үүсгэх эрсдэл үүсгэж байна. нарийн нүүрсний үйрмэгийн тархалт үйлдвэрийн хашааны зүүн хэсэг болон хашааны гаднах талбайд илэрсэн тул цаашид тээвэрлэлт, хадгалалтын горимыг нягталж, тоосжилт бага үүсгэх нөхцөлийг баримтлах хэрэгтэй юм. Дулааны цахилгаан станцад ашиглаж буй нүүрс болон түүнээс гарч буй үнсэнд агуулагдах буй хүнд элемент, цацраг идэвхт элементийн агууламжийн чиглэлээр тодорхой судалгаанууд хийгдэж ирсэн бөгөөд Багануур, Шивээ-Овоогийн уурхайгаас хангадаг голчлон ашигладаг нүүрснүүдэд U, Th, K зэрэг цацраг идэвхт элементүүд, тэдгээрийн задралын бүтээгдэхүүн болох Pb, Zn, Cd зэрэг элементийн агууламж өндөр байдаг. Эдгээр элементүүд нь салхи, усаар дамжих хүрээлэн буй орчинд хуримтлагдан дам нөлөөг үүсгэх боломжтой бөгөөд MNS5850-д заасан стандарт хэмжээнээс хэтрээгүй хэдий ч Туул голын хөндийн хөрсний хүнд элементийн агууламжаас өндөр агууламжтай, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон хорт хавдар үүсгэх эрсдэлийн түвшин өндөр байдаг. Иймд станцын үйл ажиллагаанаас үүсэж буй нүүрсний тархалт нь хүний эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөтэй учир цаашид хүрээлэн буй орчинд тархах, хуримтлагдах үйл явцад өндөр хяналт тавих нь зохистой.

3.5. УРГАМЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ

Судалгаа явуулсан талбайд ургамлын нөмрөг дунд зэрэг доройтолд орсон байлаа. Энэхүү нөлөөлөлд өртөх талбайн хэмжээ харьцангуй бага боловч бууруулах арга хэмжээг яаралтай авах хэрэгтэй, авсан тохиолдолд энэ хэсэг газрын ургамлын ургалт хэвийн болох боломжтой.

3.6. ТӨСЛӨӨС АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ

Тус үйлдвэрийн бүсэд амьтны аймгийн экосистемийн шинж төрх бүрэн алдагдаж, энэ хавийн амьтны зүйлийн бүрдэл нь хот суурин, хүний ойр орчимд амьдардаг синантроп зүйлүүд голлох болжээ. Иймд энэхүү төслийн зүгээс байгалийн амьтны аймагт төдийлөн сөрөг нөлөөлөл үзүүлэх нь бага болно.



4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Амгалан дулааны станц” ТӨХК-ний Амгалан дулааны станц төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хууль, БОНХАЖ Сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны А-117 дугаар тушаал, 2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын шаардлагад нийцүүлж боловсруулсны дагуу менежментийн төлөвлөгөөний биелэлтийг боловсруулав.

Хүснэгт 3. БОМТөлөвлөгөөний зардлын задаргааны биелэлт

№	Ажлын нэр	БОМТ Зардал (мян.төг)	Биелэлтийн зардал (мян.төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	23 580.0	212 817.0
2	Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал	1 440.0	1 500 .0
3	Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал	25 020.0	214 317.0

Хүснэгт 4. БОМТөлөвлөгөөний зардлын биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	БОМТ зардал, (мян.төг)	Биелэлтийн зардал (мян.төг)
1	Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1 580.0	32 833.0
2	Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө	18 000.0	18 845.0
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	-
4	Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-
5	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	600.0	-
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	200.0	2 064.0
7	Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал	3 200.0	157 732.0
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал урьдчилсан байдлаар		23 580.0	211 474.0



4.1. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлэгч нь 2024 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлтийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. үүнд:

- **Агаар:** Төслийн талбайн орчимд үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх, талбайд нягтарсан цементийн тоосонцрыг хусаж зайлуулах, талбайн орчмын сул шороотой хэсгүүдийг хатуу хучилттай болгох, ашиглагдахгүй талбайд хөрсний элэгдэл, эвдрэлийг бууруулах зорилгоор хаших, ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр цаг тухай бүрд хангах, ашиглагдаж буй машин тоног төхөөрөмжийн битүүмжлэлийг нэмэгдүүлэх, тээврийн хэрэгслүүдийн үзлэг оношилгоог тогтмол хийх, элс хайрганы ил задгай агуулахыг засаж тохижуулах, элс хайргыг байнга нуруулдах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал /мян.төг/ (Хавсралт-5-аар хавсаргав)

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нэгжийн өртөг (мян.төг)	БОМТ зардал (мян.төг)	Биелэлт зардал (мян.төг)
АГААР					
Нүүрс хадгалалт, тээвэрлэлт, бутлуур цех, конвейер, зуухны яндан, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, зам харгуй, ахуйн хог хаягдлын цэг зэргээс агаар дахь тоосжилт, PM, CO, SO ₂ , NO ₂ ихсэж орчны хүчилтөрөгчийн (O ₂) хэмжээ багасаж болно.	Дулааны цахилгаан станцын үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгсэл болон утааны яндангаас гарах агаар бохирдуулагчдад тогтмол хэмжилт хийх замаар хяналт тавих, зөвшөөрсөн норм хэмжээнээс хэтэрсэн тохиолдлуудад дүгнэлт хийж шалтгааныг тогтоох, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх	Ашиглалтын хугацаанд		БОХШХ-т тусгав.	319.0 /Автомашин үзлэг/
	Нүүрсний дамжуулах, хадгалах талбайн эргэн тойронд салхи тоосноос хамгаалах ургамал, ойн зурвас буй болгох замаар салхины хурд хүчийг сааруулах, өнгөн хөрсний шороо, тоос хийсэхийг багасгах	Ашиглалтын хугацаанд	500.0	500.0	-
	Хог хаягдлыг төслийн талбайн орчимд цуглуулалгүйгээр төвлөрсөн хогийн цэгт зайлуулах	Хог хаягдлын менежментэд тусгагдсан			
	Ахуйн хог хаягдал болон сэлбэг материалын хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын хогийн цэгт цуглуулах, хоёрдогч түхий эд болгож ашиглахаар ялгасан зүйлийг холбогдох цэг, үйлдвэрт тээвэрлэж хүргэх, борлуулах	Хог хаягдлын менежментэд тусгагдсан			
	Төсөл хэрэгжих хугацаанд мэргэжлийн байгууллагаар агаарын сорьц авхуулан шинжилгээ хийлгэж, зөвлөгөө авч байх	БОХШХ-т тусгагдсан.			
	Бохирдол ихтэй газар ажиллаж буй ажилчдад хувийн хамгаалах хэрэгслийг тараах, тогтмол хэрэглүүлж хэвшүүлэх	Дотоод төлөвлөлтөөр			
	Агаар бохирдуулагчид ихээр буй үүсэж цех, дамжлагуудад агааржуулалтыг тогтмол хийж байх	Дотоод үйл ажиллагаагаар			



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРС, УРГАМАЛ					
Тээврийн хэрэгслийн явалт, ажилчдын хөлөөр хөрс эвдрэх, ургамал гэмтэх, эвдрэл үүсэхээс гадна шатах тослох материал, хог хаягдал, бохирын шингэн алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсч болзошгүй	Төслийн талбайн газар ашиглалтын мэдээллийг тодорхой болгох, газар ашиглалттай холбоотой бичиг баримтыг бүрдлийг хангах, эвдэгдсэн талбайн бүртгэл хөтлөх, онц шаардлагатайгаас бусад талбайд ашиглалт явуулахгүй байх арга хэмжээ авах	Дулааны цахилгаан станцын хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр		-
	Дахин ашиглагдахгүй болсон талбайд тэмдэг тэмдэглэгээ байршуулж байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх	Дулааны цахилгаан станцын хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр		-
	Дулааны цахилгаан станцын нөлөөгөөр орчмын газар ашиглалт, хөрсний бохирдолд нөлөөлж буй нөлөөлөл байгаа эсэхийг тодорхойлох, БОХШХ-т хамруулах	БОХШХ-т тусгагдсан.			
	БОХШХ-ын үр дүнг тодорхойлж биелэлтийн тайланд тусгах, тус үр дүнд үндэслэн стандартаас илүү бохирдолтой талбайн хөрсийг солих, саармагжуулж хаях арга хэмжээг тухайн жилийн байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлж байх	Дотоод төлөвлөлтөөр			
УС					
Бохир ус агуулах, хадгалах байгууламжуу дын ус үл нэвчүүлэх хамгаалалт хагарах, бохир ус дамжуулах хоолойд гэмтэл үүсэх, шатах тослох материал асгаралт зэрэг нь бохирдлын эх үүсвэр болно.	Технологийн ус хэрэглээний бүртгэл хөтөлнө. Усны зарцуулалтыг тооцож байх, технологийн хэрэглээнд ашиглаж буй эх үүсвэр /худгууд/-ийн бичиг баримтын бүрдлийг хангаж ажиллах	Дотоод үйл ажиллагаагаар			
	Технологийн хэрэглээнд ашиглагдаж буй худгуудыг БОХШХ-т хамруулах, худгийн ундарга, нөөцөд нөлөөлөх нөлөөлөл байгаа эсэхийг тодорхойлох	Технологийн хэрэгцээнд ашиглагдаж буй 6 худгийн орчимд	-	-	11 305.0 /12-р сар усны төлбөр/
	Ахуйн бүх төрлийн бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдаж байгаа эсэхийг үе үе хянах боломжтой тоноглох, хянаж байх	Өдөр бүр	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгах		7 800.0 /2-р сар усны төлбөр/
	Хатуу хог хаягдлын цэгийг тохижуулах	Тухай бүр	Хог хаягдлын менежментэд тусгагдсан		-
АЖИЛЧИД БОЛОН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДЭД					
	Дулааны станц, ажлын байруудыг галын хор, гал унтраах иж бүрэн хэрэгслээр хангах	Жилд 1 удаа	1 000.0	1 000.0	13 409.0 /Галын аюулаас хамгаалах хэрэгсэл/
	Химийн бодисын агуулах болон түүнийг зөөж тээвэрлэх тээврийн хэрэгсэл дээр хортой аюултай бодисын анхааруулга тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	Жилд 1 удаа	80.0	80.0	-
			1 580.0	32 833.0	



4.2. НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлэгч нь 2024 онд Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд” Эрчим хүчний салбарын хэмжээнд мод тарих ажилд санхүүжилт оруулсан. Тус ажлыг “Ойн хайгуул” ХХК-н хийж гүйцэтгэсэн болно. /18 845 800/ төгрөг

Хүснэгт 6. Нөхөн сэргээлт, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөөний биелэлтийн зардал (Хавсралт 4-т хавсаргав)

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг	Нийт зардал (мян.төг)	Биелэлтийн зардал (мян.төг)
Төслийн талбайн орчим нөлөөлөлд өртсөн талбайг нөхөн сэргээх	Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл байгуулах	Эзэмшлийн талбайд	2024 онд	18 000.0	18 000.0	18 845.0 /Мод тарих гэрээт ажлын төлбөр/
Нийт зардал (мян.төг)				18 845.0		

4.3. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дулааны цахилгаан станц нь Баянзүрх дүүргийн 8-р хороонд өөрийн байранд байрладаг бөгөөд “Амгалан дулааны станц” ТӨХК нь төслийг хэрэгжүүлж эхэлсэн цагаас эхлэн орон нутгийн иргэд, оршин суугчдын эрх ашгийг нэн тэргүүнд тавьж тэдний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжид онцгой анхааран ажиллаж ирсэн билээ. Иймд төсөл хэрэгжүүлэгчийн 2024 онд хэрэгжүүлэх нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөөг дараах арга хэмжээнд чиглүүллээ.

Хүснэгт 7. Нийгэм-эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардлын биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Нэгжийн өртөг (сая.төг)	Зардал, сая.төг	Хариуцагч
1	Төслийн талбайн орчимд иргэдтэй уулзах, нөлөөллийн талаарх мэдээллийг өгч, хамтран ажиллах	2024	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан.		Төсөл хэрэгжүүлэгч
2	Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн саналыг авах, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, нийгмийн хариуцлагын чиглэлээр хийх арга хэмжээг нарийвчлан тогтоох	2024	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		Төсөл хэрэгжүүлэгч
3	Тогтоосон арга хэмжээг хэрэгжүүлэх	2024	Дотоод төлөвлөлтөөр шийднэ.		Төсөл хэрэгжүүлэгч
4	Төслийн зүгээс байгаль орчин, нийгэм эдийн засгийн зохистой үзүүлэлтийг хангах, төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс нэмэлт гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй хүлээн авч зохих хэмжээнд нь шийдвэрлэж заавал хариу өгөх.		Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		Төсөл хэрэгжүүлэгч
Нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардлын нийт дүн					-

4.4. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа явуулж буй талбайд түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй бөгөөд төслийн хэрэгжилтийн үед ямар нэг зүйл илэрвэл мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, хамгаалах арга хэмжээ авна.



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хүснэгт

8. Түүх соёлын өвд үзүүлж буй болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлтийн зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, сая.төг	Хариуцагч
1	Түүх соёлын дурсгалт эд зүйлс ашиглалтын хугацаанд илэрвэл, судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, хамгаалах чиглэлээр зөвлөмж, зааварчилгаа гаргуулж авах	2024	-	Төсөл хэрэгжүүлэгч
2	Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх соёлын дурсгалт газруудын тухай, түүнийг хөндөхгүй байх талаарх хууль эрх зүйн орчин, хамгаалах арга хэмжээний тухай ажилчдыг сургалтад хамруулах, зааварчилгаа өгөх	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө			-	

4.5. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дулааны цахилгаан станцад хэрэглэх химийн бодис нь хяналт, туршилт хийгдсэн баталгаа бүхий гэрчилгээтэй, мөн хор аюулын лавлахтай, бодисыг тохирсон зориулалтын сав, хайрцагт савлаж битүүмжилсэн, хаяг шошго наасан байх хэдий ч тээвэрлэх, шилжүүлэн ачих, хадгалах, хэрэглэхэд осол эрсдэл гарах магадлалтай.

Химийн бодисын ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэлийг сайжруулах, болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол явуулж байх нь үйлдвэрлэлийн үндсэн ажиллагааны нэг хэсэг юм.

Ашиглагдах химийн бодисуудын сав хайрцгийн овор хэмжээ, хаяглалт, холбогдох мэдээллүүд нь олон улсын стандарт, импортлогч болон хэрэглэгч үйлдвэрүүдийн технологийн дагуу хийгдсэн тохиолдолд хэвийн нөхцөлд тээвэрлэх болон шилжүүлэн ачих, хэрэглэхэд харшлах зүйлгүй гэж үздэг. Харин технологийн горимыг чанд сахихгүй байх, ажиллагсдын хайнга ажиллагаа зэргээс үүдэн осол гарвал химийн бодисын хор аюулаас үүдэн бий болох эрсдэл, үр дагавар нь их тул урьдчилан сэргийлэх иж бүрэн арга хэмжээ авч, эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах талаар бэлтгэл ажлыг зохих журмын дагуу хийсэн байх зайлшгүй шаардлагатай.

Хүснэгт 9. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардлын биелэлт

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (мян.төг)	Биелэлтийн зардал (мян.төг)
Химийн бодисын сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдах, орчинд тархах	Байнгын хяналт тавих	Станцын орчимд	Дотоод хяналт, шалгалтаар		
	Нөөцөд сав баглаа боодол байлгах (үйлдвэрт хадгалагдаж буй сав баглаа, боодлыг ариутгаж ашиглахаас гадна нөөцөд шинэ сав, баглаа боодол авч хадгалах)	Хадгалж байгаа химийн бодисын шинж чанарт тохирсон	200 мян.төг,	200.0	-
	Шаардлагатай үед алдагдсан химийн бодисыг цэвэрлэх, саармагжуулах арга хэмжээ авах, багаж хэрэгсэлтэй болох	Ус, элс шороо, хүрз, цэвэрлэгээний бодис гэх мэт	200 мян.төг	200.0	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд тусгагдсан
	Химийн бодисын үлдэгдэл, сав баглаа боодлыг тусгай зөвшөөрөлтэй аж	Дотоод төлөвлөлтөөр			



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

	ахуйн нэгжээр устгуулах				
Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх гарын авлагатай болох	Төсөл хэрэгжүүлэгчийн удирдах ажилтан албан хаагчдад үүрэг даалгавар өгөх	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		
	Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай болох	Химийн бодисыг ачиж буулгах, тээвэрлэх, хадгалах зэрэг үйл ажиллагаануудын үед хэрэгжүүлэх ХХАА-ны гарын авлагатай болох	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		
	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл, холбооны хэрэгсэлтэй болох	Ус, элс шороо, хүрз, цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт	-	-	-
	Болзошгүй аюул ослын үед ашиглах мөнгөн хуримтлал бүрдүүлэх		200.0		
Химийн бодис алдагдах, асгарах зэргээр ажилчдын эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй	Ажилчдад зориулалтын хөдөлмөр хамгааллын хувцас өмсгөх, зориулалтын угаалгын өрөөнд угааж, цэвэрлэх	Бээлий, нүдний шил, нүүрний хаалт, чихэвч	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		
Нийт зардал (мян.төг)		-			

4.6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дулааны цахилгаан станцад цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх явцад завсрын бүтээгдэхүүн гарахгүй, үйлдвэрлэлийн явцад үнс шлак, хаягдал ус, уур, нүүрсний хаягдал, утааны хий, нефтийн бүтээгдэхүүн асгарах зэрэг бодит болон болзошгүй байдлаар гарах хог хаягдал гардаг.

Завсрын бүтээгдэхүүн: ДЦС-аас завсрын бүтээгдэхүүн гарахгүй болно.

Хатуу хаягдал

Ахуйн хог хаягдал / Нэр төрөл, хэмжээ, эх үүсвэр, түүнийг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, цэвэрлэх, зайлуулах, устгах арга хэлбэр/

Эх үүсвэр: ДЦС-д ажиллагсдын ахуйн хог хаягдал, асгарсан шатахуун тосолгооны материалын цэвэрлэгээнээс гарсан алчуур, болон бусад эд зүйлс, элс гэх мэт.

Нэр төрөл: Тус ДЦС нийт 289 хүн ажиллагсадтай бөгөөд ашиглалтын 2 ээлжээр ажиллана. Иймд ахуйн хуурай хог хаягдал гардаг. Мөн шатахуун болон бусад бодис тос санамсаргүй асгарсан тохиолдолд цэвэрлэгээнээс гарсан шатахуунтай алчуур, элс зэрэг гарах магадлалтай.



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

- ✓ Ахуйн хэрэглээнээс гарсан цаас, сав, баглаа, боодол, амны цаас, гялгар уут, бичгийн хэрэгслийн цаас, амны алчуур, хүнсний бүтээгдэхүүний цаасан сав баглаа боодол, хоол хүнс бэлтгэх явцад гарсан хаягдал
- ✓ Асгарсан шатахуун тосолгооны материалыг шингээж авсан цаас, алчуур, элс шороо
- ✓ Хүмүүсийн эдэлж хэрэглэж байсан эд, гутал хувцасны уранхай, тасархай гэх мэт хог жилдээ.

